



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.08.14 № 29

**Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн
тухай хуулийн хэрэгжилтийн талаар**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1-т “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг уялдуулан батлах;”, 9.2.3-т “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах;” нь Улсын Их Хурлын бүрэн эрх болохыг тус тус тодорхойлсон.

Гэвч Улсын Их Хурлын гишүүдээс 2026 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг авч буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйл болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, хууль тогтоох байгууллагын хяналтыг сулруулж, гүйцэтгэх засаглалаас хараат ажиллах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг 2025 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэхтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилттэй холбогдох дараах асуулгыг Танд тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, тайланг ирүүлэх;

2. Дээрх баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэхдээ хуульд заасан зарчмыг хэрхэн хангасан, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд цогц үнэлгээ хийсэн эсэх талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

3. Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн, цогцоор нь тусгаж буй эсэхэд хэрхэн хяналт тавьж ажиллаж буй талаар;

2025000046

4.Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг боловсруулахдаа төсөв, санхүүгийн тооцоог эх үүсвэртэй нь уялдуулж төлөвлөсөн эсэх, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 4.1.26 дахь заалтын дагуу бодлогын уялдааны үнэлгээ, нөхцөл байдлын дүн шинжилгээг хэрхэн хийсэн талаар;

5.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтад “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г орон нутгийн онцлогт нийцсэн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь хэрхэн уялдуулан төлөвлөж буй талаар;

6.Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.5-д дунд хугацааны бодлогын баримт бичигт хөгжлийн зорилтот хөтөлбөрийг ойлгохоор заасан ч уг хөтөлбөрийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлээгүй байна. Төсвийн тухай хуулийн 6.2.7-д төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэхээр тусгасантай холбогдуулан хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын төлөвлөлт, явцын талаарх мэдээлэл;

7.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх шаардлагыг ямар шалгуур үзүүлэлтээр үнэлж, хангуулсан талаарх мэдээллийг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж ирүүлэх;

8.Алсын хараа 2050 хөгжлийн урт хугацааны баримт бичгийн 4.1 дэх зорилтод тусгагдсан төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээлэл зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Х.БААСАНЖАРГАЛ

2025000046